



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН ХОЁР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН МЭДЭЭ 12

Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол

2025 оны 11 дүгээр сарын 01 нээс 12 дугаар сарын 03 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

Архангай аймгийн Өгийнуур сумын Өгий нууранд 2025 оны 11 дүгээр сарын 05-нд өвчний сэжигтэй 1, үхсэн 1 гангар хун бүртгэгдэж, шувууг УМЭАЦТЛ-т илгээсэн ба 2025 оны 11 дүгээр сарын 08-нд сорьцод өндөр хоруу шувууны томуу өвчний Н5 дэд хэвшлийн вирусийн генийн өвөрмөц хэсэг илэрсэн.

Баянхонгор аймгийн Жаргалант сумын Давст Цагаан нууранд 2025 оны 10 дугаар сарын 20 нд 6 хун шувуу ирж 1 нь үхсэн. Үлдсэн 5 хун нь явж чадахгүй байна гэсэн дуудлага мэдээллийг нутгийн малчин сумынхаа байгаль орчны байцаагчид өгсөн. Дуудлагын дагуу 2025 оны 11 дүгээр сарын 28 нд Жаргалант сумын байгаль хамгаалагчид дээрх 5 хун шувууг сумын төвийн ногооны талбайн хүлэмжинд авчирч, хоол тэжээл өгсөн.

Өвчний сэжигтэй, өвчилсөн шувууд бүртгэгдсэн үед: ЗӨСҮТ-н 70282853 дугаарт мэдээлэл өгөх эсвэл дараах холбоосоор мэдээлэл илгээнэ үү. <https://arcq.is/KXDjy>

Хоёр. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл

2025 оны 11 дүгээр сарын 01 нээс 12 дугаар сарын 03 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн 1 тохиолдол бүртгэгдсэн.

АНУ-н Вашингтон мужийн Округ Грейс-Харбор мужид 2025 оны 11 дүгээр сарын 14 нд 1 иргэн өндөр хоруу чанартай шувууны томуугийн Н5Н5 хэвшинжээр өвдөж, эмнэлэгт хүргэгдсэн ба 2025 оны 11 дүгээр сарын 21 нд нас барсан.

Гурав. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн амьтдын мэдээлэл:


2025 оны 11 дүгээр сарын 01 нээс 12 дугаар сарын 03 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус Австри, АНУ, Бельги, Канад, Чех, Финланд, Вьетнам, Өмнөд Солонгос, Дани, Испани, Португал, Унгар, Норвеги, Өмнөд Африк, Их Британи, Герман, Итали, Унгар, Ирак, Словени, Словаки зэрэг 34 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 871 тохиолдол бүртгэгдсэн (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 2 оос харна уу). Нидерланд улсын ямаа үржүүлгийн аж ахуйд 2025 оны 11 сарын 19 нд шувууны томуу өвчнөөр муур өвчилсөн ба үргэлжлэн 7 муур шувууны томуу өвчнөөр эндсэн. 2025 оны 10 сард муур нь үхсэн шувууны сэг зэмийг авчирч идсэн. Зүүн Азийн, Европ, Америк тивийн улс оронд ихэвчлэн нүүдлийн шувуудад өвчлөл бүртгэгдсэн.

Хүснэгт 1. Шувууны томуугийн А хүрээний вирусийн хэв шинжээр тархалт

Эх сурвалж: <https://empres-i.apps.fao.org/>

Дэд хэвшинж	Улс	Зүйлийн нэр	Нийт тохиолдол
H5N5	АНУ	Хүний өвчлөл	1
H5N1	Австри	Хун, нугас, эгэл шонхор, сар шувуу	24
H5N1, H5	Бельги	Шувууны аж ахуй, тогоруу, шилийн сар, зээрд нугас, галуу, шар шувуу, шаазгай	52
H5N1	Болгар	Тогос, тодорхойгүй	3
H5N1	Камбоджи	Шувууны аж ахуй	1
H5N1	Канад	Шувууны аж ахуй	7
H5N1	Чех	Бор галуу, хун, шувууны аж ахуй	15
H5N1	Дани	Шувууны аж ахуй, тогоруу, шилийн сар, зээрд нугас, галуу, хэрээ, цахлай	27
H5N1	Финланд	Хун, галуу	8
H5N1	Франц	Шувууны аж ахуй, тогоруу, зээрд нугас, галуу	61
H5N1	Герман	Галуу, нугас, шувууны аж ахуй	340
H5N1	Унгар	Нугас, галуу, хулд, хун	13
H5N1	Ирак	Шувууны аж ахуй	1
H5N1	Ирланд	Хун	7
H5N1	Индонези	Тодорхойгүй	1
H5N1	Итали	Нугас, галуу, цахлай, шувууны аж ахуй	18
H5N1	Япон	Харцага, шувууны аж ахуй, хун, эгэл шонхор, хэрээ	46
H5N1	Норвеги	Хун, шонхор	2
H5N1	Польш	Шувууны аж ахуй, хун	15
H5N1, H5	Португал	Шувууны аж ахуй	5
H5N1	Латви	Шувууны аж ахуй, хун	13
H5N1	Словак	Хун	3
H5N1	Словени	Хун	3
H5N1	Өмнөд Солонгос	Шувууны аж ахуй	3
H5N1	Өмнөд Африк	Эгэл хараалай	1
H5N1	Испани	Шувууны аж ахуй, начин шонхор, тогоруу, нугас, галуу, өрөвтас	33
H5N1	Швед	Шувууны аж ахуй, тогоруу, шонхор	6
H5N1	Швейцар	Нугас, цахлай	8
H5N1	Их Британи	Шувууны аж ахуй, галуу, хараалж, цахлай, шонхор	77
H5N1	Нидерланд	Шувууны аж ахуй	4
H5N1, H5	Вьетнам	Шувууны аж ахуй, нугас	8
H5	Монгол	Гангар хун	1
H5N1	Украйн	Гунгар хун	1

Зураг 1. 2025 оны 11 дүгээр сарын 01 нээс 12 дугаар сарын 03 ны хооронд шувуудын дунд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусийн тохиолдлын тархалт



УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Шувууны аж ахуй эрхлэгчид:

- ❓ Шувуудыг нүүдлийн шувууд болон төв суурин газрын бусад шувуудаас тусгаарлах
- ❓ Шувууны гаралтай түүхий эдийг (мөн үхрийн сүү) хагас боловсруулсан байдлаар хэрэглэхгүй байх
- ❓ Төмөр тор, тоног төхөөрөмж, байрны бетон шал болон шалны хөндлөвч, хог зайлуулах суваг, шувууны суултуур, тэжээлийн сав, услуур зэрэгт халдваргүйжүүлэлтийг холбогдох зааврын дагуу хийх

Малчид, ард иргэдэд:

- ❓ Сэжигтэй /өвчилсөн, үхсэн/ шувуудад ойртохгүй байх, мэдээлэх (Франц улсын өмнөд бүс нутагт 2023 онд шувууны томуугийн өвчлөл цахлай шувуунд бүртгэгдэж эхэлсэн ба шувуу болон гадаад шимэгч болох хачигт шинжилгээ хийж томуугийн вирус ялган оношилсон.
<https://www.biorxiv.org/content/10.1101/2025.11.28.689408v1>)
- ❓ Гол, нуурын эргээр техник хэрэгслээр явсан тохиолдолд гэрээс хол зогсоолд байршуулах, гуталны улыг арчиж гэртээ орох
- ❓ Шувууд олноор эндсэн нуурын усыг ахуйн хэрэгцээнд хэрэглэхгүй байх
- ❓ Өвчний сэжигтэй буюу шалтгаан тодорхойгүй эцэж цуцсан, халуурсан, сүүний гарц, хоолны дуршил буурсан үхрийн сүүг хагас боловсруулсан байдлаар хэрэглэхгүй байх

**Нүүдлийн шувуудаа хайрлаж
Тэжээвэр шувуудаа хашиж**

Хамгаалъя!!